



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 02 дугаар сарын 20

№ 01/36 ДУА-2018/А/СТА-ОИТС Мандалговь хот

Зөрчлийг арилгуулах тухай

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Сайнцагаан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад сангийн хөрөнгөөс 12,230,654.00 /Арван хоёр сая хоёр зуун гучин мянга зургаан зуун тавин дөрөв/ төгрөгийг сумын иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй зориулалт бус “Цагдаагийн бэлэн бус торгуулийн тоног төхөөрөмж худалдан авах”, “Олон нийтийн цагдаа нарыг унаажуулах”, “Сумын цагдаагийн кабоны барилга, аймгийн цагдаагийн постын барилгыг дулааны шугамд холбох засварын ажил” зардалд зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.6.2.-т /төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх;/, 6.6.6.-т /тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх./, 16 дугаар зүйл 16.5.5.-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;/, 58 дугаар зүйлийн 58.4.10.-т /орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх;/, 60 дугаар зүйлийн 60.3-т /Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно/, 60.3.1.-д /орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүрээс бусад хөтөлбөр, арга хэмжээ/, 60.3.6-д /орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ/, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай” журмын 4 дүгээр зүйлийн 4.5-т Орон нутгийн төсвийн бус байгууллагуудад ОНХС-аас хөрөнгө зарцуулахгүй байх; / заасныг тус тус зөрчсөн байна.



Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95

дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.4-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн;/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Сангийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ нь хууль журамд нийцэж байгаа эсэхэд хяналт хийж Төсвийн тухай хуулийн шаардлагыг хангаагүй, зориулалтын бус зардалд зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хасч тодотгох;

2. Цаашид орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хуулиар хориглосон хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд зарцуулахгүй, хууль, журмыг мөрдөж ажиллах.

Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Сайнцагаан сумын Засаг дарга Р.Мөнхтогтох, Засаг даргын орлогч Ч.Ганбаатар, Санхүүгийн албаны дарга С.Бархасмаа, нягтлан бодогч Ж.Бурмаа нарт хариуцуулав.

| | | |
|--|---|--|
|  <p>АХЛАХ АУДИТОР Д.ИХБАЯР</p> | <p>АЛБАН ШААРДЛАГЫГ</p> <p>ӨГСӨН:</p> |  <p>ЗӨВНӨӨРСӨН: САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА</p> |
| | <p>ЗАСАГ ДАРГА ОРЛОГЧ ДАРГА</p> | <p>Р.МӨНХТОГТОХ Ч.ГАНБААТАР С.БАРХАСМАА</p> |
| | <p>НЯГТЛАН БОДОГЧ</p> | <p>Ж.БУРМАА</p> |

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.